

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын гэрчилгээ.....	2
Аудитын тайлан.....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.12 Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
Менежментийн захидал.....	9
Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	18
Хавсралт.....	19
5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19
5.2 Албан шаардлага.....	20
5.3 Төлбөрийн акт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ОЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ Д.МӨНХБАТ
ТАНАА

2020.02.21 № 06/577
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ойн судалгаа хөгжлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ойн судалгаа хөгжлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ойн судалгаа хөгжлийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1 Оршил

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Д.Мөнхбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, зардлын данс болон үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналыг холбогдох стандарт, журам, зааврын дагуу хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 11-нээс 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Э.Энхбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Ойн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулахад шаардлагатай мэдээллийг шинжлэх ухаан, техникийн

дэвшилтэд арга технологид тулгуурлан ойн тогтвортой хөгжлийг хангахуйцаар боловсруулж бүрдүүлэх, ногоон хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд өөрийн чиг үүргийн дагуу оролцоход оршино.

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Тухайлбал:

- Мод, сөөгний үрийн дээжид шинжилгээ хийх, ойн шилмэл үрийн нөөц бүрдүүлэх, хадгалах, худалдан борлуулах;
- Монгол оронд ургадаг модлог ургамлын цуглуулгын цэцэрлэгт хүрээлэнгийн /Дендрари/ үйл ажиллагаа эрхлэх;
- Ойн тооллого, ойн зохион байгуулалтын ажлын тайланг нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, сэдэвчилсэн зураг боловсруулах;
- Ойжуулалтын ажлын зураг төсөл хийх, таримал ойг улсын ойн санд хүлээн авах эсэх талаар дүгнэлт гаргах;
- Хууль бус мод бэлтгэл, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа бусад арга хэмжээг зохион байгуулах, хяналт мониторинг хийх;
- Ойн хөнөөлт шавж, өвчний голомтын судалгаа хийж дүгнэлт гаргах;
- Ойн тооллого, ой зохион байгуулалт, хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт мониторинг хийх;
- Ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах болон ойн арчилгаа, цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах, сургалт, хяналт, мониторинг хийх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Acolous программ хангамж ашигладаг байна.

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 14 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн

санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 10,961,451.6 мянган төгрөгөөс тооцон 109,614.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувь буюу 60,300.9 мянган төгрөгөөр тооцсон нь ойжуулалт, ойн арга хэмжээний батлагдсан төсөв өмнөх оноос 4,600,000.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой болно.

2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41,114.6 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	71,856.6	7,884.8	-63,971.8
Бараа материал	1,200,125.4	827,424.4	-372,701.0
Үндсэн хөрөнгө	7,738,008.5	8,133,566.7	395,558.2
Нийт хөрөнгө	9,009,990.5	8,968,875.9	-41,114.6
сӨр төлбөр	0.9	-	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,009,989.6	8,968,875.9	-41,113.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,009,990.5	8,968,875.9	-41,114.6

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь тусгай зориулалтын материал, бусад хангамжийн материалын зарцуулалтаас шалтгаалжээ. Тусгай зориулалтын бараа материал 188,684.9 мянган төгрөгөөр худалдан авч 353,166.7 мянган төгрөгийн материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/38 дугаар тушаалд Ойн цэвэрлэгээнд дэвшилтэт техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэх ажлын хүрээнд 600,000.0 мянган төгрөгөөр иж бүрэн экскаватор, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажилд 16 автомашиныг 494,400.0 мянган төгрөгөөр худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 77,727.3 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 5,957,882.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 229,882.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 5,728,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,944,444.5 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь хөрөнгийн зардлын хэмнэлтээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Өмнөх оны гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилтийг давхардуулан олгосны авлага 9,135.8 мянган, дээд шатны төсвийн захирагчаас 10,737.5 мянган, нийт 19,873.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид зарцуулсан байна.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 6 эрсдэл тодорхойлж нийт 20 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 429,820.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 414,541.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,884.8 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 7,394.4 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/38 тушаалаар баталсан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажилд зориулан худалдан авч, аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар, сум дундын ойн ангиуд руу шилжүүлсэн 13 УАЗ Фургон автомашиныг хөрөнгийн зардалд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад 401,700.0 мянган төгрөгийн залруулга хийсэн.

2. Төв аймгийн Эрдэнэ сумын хомсдол, доройтолд өртсөн ойд ойн цэвэрлэгээ хийж байгалийн сэргэн ургалтад туслах ажил гүйцэтгэх 2019 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн №178 дугаар, 11,264.0 мянган төгрөгийн үнийн дүнтэй гэрээний гүйцэтгэгч Үндэсний ойжилт ХХК-д урьдчилгаа санхүүжилт 7,884.8 мянган төгрөгийг олгосон боловч гэрээт ажлыг гүйцэтгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн 7,884.8 мянган төгрөгийн акт тогтоосон.

3. Ойн цэвэрлэгээний ажил гүйцэтгэх тухай гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн Улаанбаатар хотын түлээний модны хэрэгцээний тодорхой хувийг хангах зорилгоор борлуулалтын цэгүүдээр тараасан модны зарцуулалтад гэрээний дагуу хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн байдлаарх аж ахуйн нэгжүүдээс нийлүүлсэн 16625 шуудай, 930 куб.метр модны үлдэгдлийг хэрхэн зарцуулах талаар тодорхой шийдвэргүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 7,394.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хөрөнгийн зардлын бусад хөрөнгийн төсвийн ангилалд батлагдсан ойжуулалт, ойн арга хэмжээний зардлын 5,728,000.0 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэлийг дараагийн аудитаар авч үзнэ.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 137 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 50,887.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосноос 28,237.0 мянган төгрөгийг барагдуулсан, Өмнөговь аймагт загийн бортоготой тарьцаар ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээний гүйцэтгэгч Очир Энерги ХХК-аар 22,650.0 мянган төгрөгийн актын төлбөрийг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан нь шийдэгдээгүй, 34,896.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг хэрэгжүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилт 96 хувьтай байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлснийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Эд хогшил, урсгал засварын зардлын батлагдсан төсвийг 7,394.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, холбогдох хууль, журам зааврын заалтыг мөрдөж ажиллаагүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

3.1.5 Илрүүлэлт:

Ойжуулалт, ойн арга хэмжээ хөтөлбөрийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу задалж батлаагүй, Хөрөнгийн зардлын бусад хөрөнгийн ангилалд бөөн дүнгээр нь бүртгэж, тайлагнасан байна.

3.1.6 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах.

3.1.7 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 2 дугаар хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал"-ын дагуу баталж, гүйцэтгэлийг гаргах.

3.1.8 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.1.9 Илрүүлэлт:

Ойжуулалт, ойн арга хэмжээ хөтөлбөрийн батлагдсан төсвөөс худалдан авсан 13 УАЗ Фургон автомашин, Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-т ашиглагдаж байсан 3 УАЗ Фургон автомашиныг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тушаал шийдвэргүй аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон сум дундын ойн ангиуд руу шилжүүлсэн байна.

3.1.10 Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх.

3.1.11 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах,

3.1.12 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,271,982,077.09	835,309,261.35
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
33	АВЛАГА	71,856,657.97	7,884,800.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	12,417,500.00	0.00
33500	Бусад авлага	59,439,157.97	7,884,800.00
33510	Байгууллагаас авах авлага	59,439,157.97	7,884,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,200,125,419.12	827,424,461.35
35100	Түүхий эд материал	231,875,200.80	67,393,425.25
35110	Тусгай зориулалттай материал	231,875,200.80	67,393,425.25
35300	Бэлэн бүтээгдэхүүн	11,906,018.80	0.00
35400	Хангамжийн материал	956,344,199.52	760,031,036.10
35420	Аж ахуйн материал	2,028,000.00	0.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,900,000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	951,416,199.52	760,031,036.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,738,008,454.87	8,133,566,669.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,738,008,454.87	8,133,566,669.61
39200	Биет хөрөнгө	1,565,735,788.21	1,968,127,336.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	147,090,630.00	147,090,630.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-14,277,933.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,477,614,481.38	1,992,587,211.38
39204	Хуримтлагдсан элэгдэл	-436,577,144.39	-586,817,063.12
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	745,655,207.71	907,723,607.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	-403,714,235.33	-516,267,705.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,783,729.33	43,783,729.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,787,018.81	-24,582,222.77
39214	Бусад үндсэн хөрөнгө	45,926,710.00	55,926,710.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-33,256,571.68	-37,039,627.10
39300	Биет бус хөрөнгө	6,172,272,666.66	6,165,439,333.30
39301	Программ хангамж	14,247,000.00	14,247,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,580,333.34	-8,413,666.70
39303	Бусад биет бус хөрөнгө	6,159,606,000.00	6,159,606,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,009,990,531.96	8,968,875,930.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	920.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	920.00	0.00
41300	Өглөг	920.00	0.00
41360	Бусад өглөг	920.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	920.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,009,989,611.96	8,968,875,930.96
51	Засгийн газрын хувь оролцоо	9,009,989,611.96	8,968,875,930.96
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,696,476,268.14	6,696,476,268.14
51200	Хуримтлагдсан үр дүн	2,238,018,957.63	2,196,905,276.63
51210	Өмнөх үеийн үр дүн	3,870,865,320.87	2,238,018,957.63
51220	Тайлант үеийн үр дүн	-1,632,846,363.24	-41,113,681.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	75,494,386.19	75,494,386.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,009,990,531.96	8,968,875,930.96

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,328,605,211.90	5,988,979,670.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	98,553,220.90	29,421,770.00
120	Нийтлэг татварын бус орлого	98,553,220.90	29,421,770.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	98,553,220.90	14,031,770.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	14,031,770.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,009,130.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	35,544,090.90	0.00
120009	Бусад орлого	0.00	15,390,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,230,051,991.00	5,959,557,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	212,436,900.00	5,957,882,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	212,436,900.00	5,957,882,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,017,615,091.00	1,675,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	422,395,091.00	1,675,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,595,220,000.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,947,895,895.10	5,622,995,623.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,947,895,895.10	716,814,882.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,675,704,037.63	670,599,713.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	386,885,143.09	186,584,793.91
210101	Үндсэн цалин	347,182,779.09	120,087,540.91
210102	Нэмэгдэл	11,654,364.00	56,197,253.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,048,000.00	10,300,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,375,239.94	23,283,258.00
210201	Тэтгэврийн даатгал	29,615,080.94	15,825,914.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,715,651.00	1,864,338.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,172,546.00	1,491,469.00
210204	Ажилгүйдлийн даатгал	538,214.00	372,868.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,333,748.00	3,728,669.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,468,800.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	2,600,000.00	0.00
210302	Түлш, халаалт	15,868,800.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	159,660,934.24	21,897,924.30
210401	Бичиг хэрэг	25,573,801.00	8,410,950.00
210402	Тээвэр, шатахуун	127,423,440.00	7,556,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,892,693.24	4,505,374.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	771,000.00	1,425,200.00
2105	Нормативт зардал	1,141,500.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,141,500.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,390,300.00	7,400,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	791,000.00	0.00
210604	Урсгал засвар	26,599,300.00	7,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	229,994,931.00	36,518,800.00
210701	Гадаад албан томилолт	78,286,330.00	0.00
210702	Дотоод албан томилолт	151,708,601.00	36,518,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,722,851,044.90	28,210,880.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,719,782,044.90	26,673,280.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	792,000.00	792,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	633,600.00	587,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	158,400.00	158,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,088,936,144.46	366,704,057.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,803,534,201.06	2,891,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,689,829.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	257,712,114.40	363,812,457.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	272,191,857.47	46,215,168.55
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	272,191,857.47	46,215,168.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,744,452.71	46,215,168.55
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	245,447,404.76	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	4,906,180,740.98
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	4,906,180,740.98
223001	Бусад хөрөнгө	0.00	4,906,180,740.98
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,619,290,683.20	365,984,046.53
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,555,680.04	407,097,727.53
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	5,397,727.53
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	401,700,000.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	13,555,680.04	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,632,846,363.24	-41,113,681.00

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	9,293,061,121.00	6,010,532,950.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,437,000.00	29,421,770.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,437,000.00	29,421,770.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,437,000.00	14,031,770.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	14,031,770.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,437,000.00	0.00
120009	Бусад орлого	0.00	15,390,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,281,624,121.00	5,981,111,180.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	212,436,900.00	5,957,882,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	212,436,900.00	5,957,882,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,069,187,221.00	23,228,280.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	422,395,091.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,595,220,000.00	12,417,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	51,572,130.00	10,810,780.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,539,008,821.00	291,452,775.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,539,008,821.00	291,452,775.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,254,399,463.53	245,237,606.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	388,754,439.09	165,754,192.00
210101	Үндсэн цалин	317,009,029.09	109,103,163.00
210102	Нэмэгдэл	33,154,147.00	42,804,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,591,263.00	13,846,129.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,698,633.20	21,174,700.00
210201	Тэтгэврийн даатгал	28,362,838.00	14,398,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,797,769.00	1,694,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,238,241.00	1,355,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	554,638.00	338,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,745,147.20	3,388,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,468,800.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	2,600,000.00	0.00
210302	Түлш, халаалт	15,868,800.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	161,889,067.24	19,095,834.94
210401	Бичиг хэрэг	20,904,539.00	6,145,450.00
210402	Тээвэр, шатахуун	128,578,255.00	6,916,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,234,503.24	4,608,784.94
210404	Ном, хэвлэл	123,020.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,048,750.00	1,425,200.00
2105	Нормативт зардал	17,193,500.00	2,845,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,193,500.00	2,845,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,476,110.00	8,820,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,461,000.00	0.00
210602	Тавилга	1,564,340.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,739,000.00	1,420,000.00
210604	Урсгал засвар	28,711,770.00	7,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	151,707,247.00	3,364,400.00
210702	Дотоод албан томилолт	151,707,247.00	3,364,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,326,784,348.00	21,450,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,323,715,348.00	19,873,280.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	0.00

210803	Даатгалын үйлчилгээ	792,000.00	792,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	633,600.00	627,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	158,400.00	158,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,427,319.00	2,732,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,717,720.00	2,732,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,709,599.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	284,609,357.47	46,215,168.55
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	284,609,357.47	46,215,168.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,744,452.71	46,215,168.55
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	257,864,904.76	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	754,052,300.00	5,719,080,174.51
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	754,052,300.00	5,719,080,174.51
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	754,052,300.00	5,719,080,174.51
2200	Дотоод эх үүсвэрээр	754,052,300.00	5,719,080,174.51
223001	Бусад хөрөнгө	0.00	4,552,611,774.51
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	754,052,300.00	1,166,468,400.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-754,052,300.00	-5,719,080,174.51
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	536,870,268.14	0.00	3,870,865,320.87	4,407,735,589.01
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	536,870,268.14	0.00	3,870,865,320.87	4,407,735,589.01
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	75,494,386.19	0.00	75,494,386.19
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	6,159,606,000.00	0.00	0.00	6,159,606,000.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,632,846,363.24	1,632,846,363.24
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,696,476,268.14	75,494,386.19	2,238,018,957.63	9,009,989,611.96
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,696,476,268.14	75,494,386.19	2,238,018,957.63	9,009,989,611.96
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-41,113,681.00	-41,113,681.00
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,696,476,268.14	75,494,386.19	2,196,905,276.63	8,968,875,930.96

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,957,882,900.00	5,944,444,501.45	13,438,398.55	99.8
УРСГАЛ ЗАРДАЛ	229,882,900.00	225,364,326.94	4,518,573.06	98.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	229,882,900.00	225,364,326.94	4,518,573.06	98.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	169,395,900.00	165,754,192.00	3,641,708.00	97.9
Үндсэн цалин	112,441,000.00	109,103,163.00	3,337,837.00	97.0
Нэмэгдэл	42,804,900.00	42,804,900.00	0.00	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	14,150,000.00	13,846,129.00	303,871.00	97.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,174,700.00	21,174,700.00	0.00	100.0
Тэтгэврийн даатгал	14,398,700.00	14,398,700.00	0.00	100.0
Тэтгэмжийн даатгал	1,694,000.00	1,694,000.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	1,355,200.00	1,355,200.00	0.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	338,800.00	338,800.00	0.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	3,388,000.00	3,388,000.00	0.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	369,800.00	0	369,800.00	0.0
Гэрэл, цахилгаан	364,100.00	0	364,100.00	0.0
Түлш, халаалт	5,700.00	0	5,700.00	0.0
Хангамж, бараа материалын зардал	19,278,600.00	19,095,834.94	182,765.06	99.1
Бичиг хэрэг	6,145,900.00	6,145,450.00	450.00	100.0
Тээвэр, шатахуун	6,917,100.00	6,916,400.00	700.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,790,000.00	4,608,784.94	181,215.06	96.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,425,600.00	1,425,200.00	400.00	100.0
Нормативт зардал	2,851,200.00	2,845,600.00	5,600.00	99.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,851,200.00	2,845,600.00	5,600.00	99.8
Эд хогшил, урсгал засварын зардал	8,825,600.00	8,820,000.00	5,600.00	99.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,425,600.00	1,420,000.00	5,600.00	99.6
Урсгал засвар	7,400,000.00	7,400,000.00	0.00	100.0
Томилолт, зочны зардал	3,433,100.00	3,364,400.00	68,700.00	98.0
Дотоод албан томилолт	3,433,100.00	3,364,400.00	68,700.00	98.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,584,000.00	1,577,600.00	6,400.00	99.6
Даатгалын үйлчилгээ	792,000.00	792,000.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	633,600.00	627,200.00	6,400.00	99.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	158,400.00	158,400.00	0.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,970,000.00	2,732,000.00	238,000.00	92.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,970,000.00	2,732,000.00	238,000.00	92.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,728,000,000.00	5,719,080,174.51	8,919,825.49	99.8
Бусад хөрөнгө	5,728,000,000.00	5,719,080,174.51	8,919,825.49	99.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,957,882,900.00	5,929,054,501.45	28,828,398.55	99.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,957,882,900.00	5,915,022,731.45	42,860,168.55	99.3
Улсын төсвөөс санхүүжих	5,957,882,900.00	5,915,022,731.45	42,860,168.55	99.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	14,031,770.00	-14,031,770.00	0.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	14,031,770.00	-14,031,770.00	0.0

ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	25	25	0	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
Төсвийн байгууллага	1	1	0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	12	12	0	100.0
Удирдах ажилтан	2	2	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	10	10	0	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12	12	0	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12	0	100.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		19,873,280.00
УРСГАЛ ЗАРДАЛ		19,873,280.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		19,873,280.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		19,873,280.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		19,873,280.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		19,873,280.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		19,873,280.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		9,135,780.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,737,500.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Огноо: 2020/02/20	Аудитын нэр:	<i>Ойн судалгаа хөгжлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит</i>	Аудитын код: САГ-2020/26/ СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр	Ойн судалгаа хөгжлийн төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	6	7
1	Ойжуулалт, ойн арга хэмжээний гэрээт ажлыг гүйцэтгээгүй аж ахуйн нэгжид олгосон урьдчилгаа санхүүжилт	7,884.8	Төлбөрийн акт тогтоох			Захирал, Нягтлан бодогч	Д.Мөнхбат Д.Ганчимэг
2	Ойн цэвэрлэгээний ажил гүйцэтгэх аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын цэгүүдээр тараасан модны зарцуулалтад хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, нийлүүлсэн модыг хэрхэн зарцуулах тодорхой шийдвэргүй, гэрээ дүгнэсэн актгүй.	-	Албан шаардлага хүргүүлэх				
3	Эд хогшил, урсгал засварын зардлын батлагдсан төсвийг 7,394.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.	7,394.4	Зөвлөмж өгөх				
4	Ойжуулалт, ойн арга хэмжээ хөтөлбөрийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу задалж батлаагүй, Хөрөнгийн зардлын бусад хөрөнгийн ангилалд бөөн дүнгээр нь бүртгэж, тайлагнасан байна.	-	Зөвлөмж өгөх				
5	Ойжуулалт, ойн арга хэмжээ хөтөлбөрийн батлагдсан төсвөөс худалдан авсан 13 УАЗ Фургон автомашин, ашиглаж байсан 3 УАЗ Фургон автомашиныг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тушаал шийдвэргүй аймгийн БОАЖГ, болон сум дундын ойн ангиуд руу шилжүүлсэн байна	-	Зөвлөмж өгөх				
Нийт		15,279.2					



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 03 дугаар сарын 02

№ 01/31

Улаанбаатар хот

СЭГ-2020/26/СТА-ТЧЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Ойн судалгаа хөгжлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/62, А/216 дугаартай “Тусгай хамгаалалттай газар нутгийн ойд цэвэрлэгээ хийх” тухай тушаалд ойн цэвэрлэгээний ажилд аж ахуйн нэгж, байгууллагыг хууль, дүрэм, журамд нийцүүлэн сонгон шалгаруулж, гүйцэтгүүлэхээр баталсан байна.

Ойн цэвэрлэгээний ажил гүйцэтгэх тухай гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн Улаанбаатар хотын түлээний модны хэрэгцээний тодорхой хувийг хангах зорилгоор борлуулалтын цэгүүдээр тараасан модны зарцуулалтад гэрээний дагуу хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн байдлаарх аж ахуйн нэгжүүдээс нийлүүлсэн 16625 шуудай, 930 куб.метр модны үлдэгдлийг хэрхэн зарцуулах талаар тодорхой шийдвэргүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.

Энэ нь ойн цэвэрлэгээний ажил гүйцэтгэх тухай гэрээний 1.6 дахь заалт “Улаанбаатар хотын түлээний модны хэрэгцээний тодорхой хувийг хангах зорилгоор, гүйцэтгэгчийн зүгээс нийлүүлэгдэж буй бүтээгдэхүүнийг борлуулалтын цэгүүдэд түгээх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хүрээнд ойгоос бэлтгэсэн модны зарцуулалтад хяналт тавих ажлуудыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх,
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ойн судалгаа хөгжлийн төвийн захирал Д.Мөнхбат, нягтлан бодогч Д.Ганчимэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

ЗӨВШӨӨРСӨН:

ОЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ

НЯГТЛАН БОДОГЧ

Д.МӨНХБАТ

Д.ГАНЧИМЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 02 № 01/22
СЯТ-2020/26/СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Ойн судалгаа хөгжлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Эрдэнэ сумын хомсдол, доройтолд өртсөн ойд ойн цэвэрлэгээ хийж байгалийн сэргэн ургалтад туслах ажил гүйцэтгэх 2019 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн №178 дугаар, 11.3 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээний гүйцэтгэгч Үндэсний ойжилт ХХК-д урьдчилгаа санхүүжилт 7.9 сая төгрөгийг олгосон боловч гэрээт ажлыг гүйцэтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гүйцэтгээгүй ажилд олгосон 7.9 сая төгрөгийн санхүүжилтийн төлбөрийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь 100900000601 тоот дансанд 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх,
2. Биелэлтийг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ойн судалгаа хөгжлийн төвийн захирал Д.Мөнхбат, нягтлан бодогч Д.Ганчимэг нарт даалгав.

АКТЫГ:

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *[Signature]*
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР *[Signature]*
Э.МӨНХБААТАР

ЗӨВШӨӨРСӨН:
ОЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ *[Signature]*
Д.МӨНХБАТ
НЯГТЛАН БОДОГЧ *[Signature]*
Д.ГАНЧИМЭГ

Акт, албан шаардлагын, биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

